

**ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ТЭНХИМИЙН
ХАВАР, НАМРЫН УЛИРЛЫН ХИЧЭЭЛ**

ЗААВАЛ СУДЛАХ ХИЧЭЭЛИЙН ЖАГСААЛТ

№	Хичээлийн нэр	Улирал Өдрийн анги	Улирал Оройн анги	Улирал Эчнээ анги
1	Монгол Улсын Иргэний эрх зүй /ерөнхий анги/	IV	II	II
2	Монгол Улсын Иргэний эрх зүй /тусгай анги/	V	III	III
3	Арилжааны эрх зүй	V	-	V
4	Монгол Улсын Иргэний процессын эрх зүй	VI	IV	V
5	Олон улсын хувийн эрх зүй	VI	III	IV
6	Хөдөлмөрийн эрх зүй	VI	IV	V
7	Гэр бүлийн эрх зүй	VII	IV	IV
8	Иргэний хууль тогтоомжийн хэрэглээ – 1	VII	-	-
9	Арилжааны эрх зүйн хэрэглээ	VIII	-	VII
10	Хууль зүйн англи хэл – 1	V	-	-
11	Хууль зүйн англи хэл – 2	VI	-	-
12	Иргэний хууль тогтоомжийн хэрэглээ (олон улс)	VII	-	-
13	Олон улсын хувийн эрх зүй (олон улс)	VII	-	-
14	Хууль зүйн англи хэл – 3	VII	-	-
15	Олон улсын хувийн эрх зүйн гэрээний хэрэглээ	VIII	-	-

16	Хууль зүйн англи хэл – 4	VIII	-	-
17	Хууль зүйн англи хэл - 5	X	-	-
18	Иргэний хууль тогтоомжийн хэрэглээ оройн анги	-	V	-
19	Иргэний хууль тогтоомжийн хэрэглээ эчнээ анги	-	-	VII

СОНГОН СУДЛАХ ХИЧЭЭЛИЙН ЖАГСААЛТ

№	Хичээлийн нэр	Улирал Өдрийн анги	Улирал Оройн анги	Улирал Эчнээ анги
1	Ромын эрх зүй	III	I	I
2	Компанийн эрх зүй	VII	III	IV
3	Оюуны өмчийн эрх зүй	VII	V	V
4	Гэм хорын эрх зүй	VII	III	IV
5	Өв залгамжлалын эрх зүй	VII	V	V
6	Иргэний процессын эрх зүй дэх нотолгооны онол, арга зүй	VII	V	VI
7	Арилжааны хэлцлийн эрх зүй Тайлбарыг үзнэ үү	VII	-	VI
8	Харьцуулсан эрх зүй	VIII	V	VI
9	Үнэт цаасны эрх зүй	VIII	III	IV
10	Эдийн баялгийн эрх зүй	VIII	III	IV

11	Гэрээний эрх зүй	VIII	III	IV
12	Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүй	VIII	V	VI
13	Шүүхийн бус аргаар маргааныг шийдвэрлэх эрх зүй	VIII	V	V
14	Олон улсын оюуны өмчийн эрх зүй	VIII	V	VI
15	Олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүй	VIII	V	V
16	Олон улсын иргэний процессын эрх зүй	VIII	V	VI
17	Иргэний хууль тогтоомжийн хэрэглээ – 3 Тайлбарыг үзнэ үү	X	-	-
18	Компаний санхүүгийн эрх зүй	X	V	VI
19	Олон улсын гэр бүл, өв залгамжлалын эрх зүй	X	V	VI
20	Олон улсын бизнесийн гэрээ байгуулах практик	X	V	V
21	Олон улсын худалдааны гэрээний эрх зүй	X	V	V
22	Гэр бүлийн эрх зүй Тайлбарыг үзнэ үү	VII	-	-
23	Хөдөлмөрийн эрх зүй Тайлбарыг үзнэ үү	VIII	-	-

Тайлбар:

1. Гэр бүлийн эрх зүй, Хөдөлмөрийн эрх зүй хичээлийн хувьд зөвхөн олон улсын эрх зүйн ангийн оюутнууд сонгон судлах хичээлийн хувиар судлах боломжтой.
2. Иргэний хууль тогтоомжийн хэрэглээ – 3 хичээлийн хувьд орой, эчнээ ангийн оюутнууд судлах боломжгүй.
3. Арилжааны хэлцлийн эрх зүй хичээлийн хувьд оройн ангийн оюутнууд судлах боломжгүй.

1. ИРГЭНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ – 3

Хичээлийн зорилго

Иргэний эрх зүйн ерөнхий болон тусгай ангийн хичээлийн хүрээнд олгогдсон иргэний эрх зүйн зохицуулалтын онолын, догматик мэдлэг, иргэний хууль тогтоомжийн хэрэглээ 1, иргэний хууль тогтоомжийн хэрэглээ 2 хичээлээр олж авсан иргэний хууль тогтоомжийн хэм хэмжээг хэрэглэх аргачлал дээр суурилан энэ хичээлээр практикт гарч буй иргэний эрх зүйн маргааныг шийдвэрлэх ур чадварыг эзэмшинэ. Ийнхүү практикт гарч буй иргэний эрх зүйн маргааныг шийдвэрлэх аргачлалыг гүнзгийрүүлэн эзэмшсэнээр хуульчийн сэтгэхүйг хөгжүүлэх, эрх зүйч мэргэжлээр төгссөний дараа хуульч болох үе шатанд бэлдэх, улмаар ирээдүйд шүүгч, өмгөөлөгчөөр ажиллах сонирхолтой оюутнуудад шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсгийг бичих дадал суулгах, маргааныг өмгөөлөхөд үндэслэл, аргумент оновчтой гаргах чадавхийг эзэмших боломжтой.

Хичээлийн агуулга

(Иргэний хуулиар хамгаалагдсан субъектив эрх зөрчигдсөн тохиолдлууд, маргааныг Иргэний хуулийн заалт, зохицуулалтыг хэрэглэн үндэслэлтэйгээр шийдвэрлэх, дасгал хийх, шүүх, арбитрын шийдвэрлэсэн хэргийг задлан шинжилж, түүнд хууль зүйн дүгнэлт гаргах, энэ явцад тохиолдлыг бодоход шаардах эрхийн үндэслэлийг зөв тогтоох, өөр өөр төрлийн шаардах эрхийн үндэслэлийн урьдчилсан нөхцлийг тогтоох, хоёрдагч, туслах чанарын хэм хэмжээг зөв тогтоож, субсумци хийх, хэм хэмжээний өрсөлдөөний үед хэрэглэгдэх хэм хэмжээг сонгох аргачлалд суралцах, тохиолдлыг бодоход ач холбогдол бүхий эрх зүйн тулгамдсан асуудлыг тодорхойлох, Иргэний хууль тогтоомжийг төсөөтэй хэрэглэх аргачлалыг бататган, бэхжүүлэх, хэм хэмжээг хэрэглэхэд хэрэглээд тайлбарлах эсхүл тайлбарлаад хэрэглэх аргачлалыг эзэмших, гэрээг тайлбарлах, гэрээний төрлийг зөв тогтоох, давхардсан зохицуулалтыг оновчтой хэрэглэх аргачлалыг эзэмших, Иргэний эрх зүйн материаллаг хэм хэмжээг, процессын эрх зүйн хэм хэмжээг хамт хэрэглэх аргачлалыг бэхжүүлэх чадавхийг хөгжүүлнэ.

2. ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ

Хичээлийн зорилго:

Энэ хичээлээр хувийн эрх зүйн харилцаанд оролцох гэж буй этгээдүүдийн хооронд ирээдүйд үүсэх үүргийн эрх зүйн харилцааг зохицуулахад чиглэгдсэн гэрээний агуулгыг талуудын ашиг сонирхлыг тусган, холбогдох хууль тогтоомж дахь хэм хэмжээг хэрэглэсний үндсэн дээр боловсруулах гэрээ байгуулахад хэрэглэгдэх хэлэлцээр хийх аргачлалыг эзэмшүүлнэ.

Хичээлийн агуулга:

- Гэрээний тухай ойлголт, гүйцэтгэх чиг үүрэг
- Гэрээний төсөл боловсруулах, бодлого бодох үйл ажиллагааны нийтлэг болон ялгаатай тал

Гэрээний төсөл боловсруулах үе шат:

- Мэдээлэл цуглуулах
- Эрсдэлийн болон амжилтын төлөвлөлт
- Гэрээний анхны төсөл боловсруулах
- Холбогдох хууль тогтоомж дахь хэм хэмжээг хэрэглэх
- Чек-лист бэлдэх
- Гэрээний төслийг дахин хянах
- Гэрээний бүтэц
- Гэрээ байгуулахад хэлэлцээр хийх тактик
- Гэрээний төсөл боловсруулах дасгал

3. ЭДИЙН БАЯЛГИЙН ЭРХ ЗҮЙ

Хичээлийн зорилго:

Энэ хичээлээр эрх зүйн этгээдүүдийн хооронд үүссэн эдийн бус баялгийн эрх, эзэмшил, эд юмсын бүрэн ба хязгаарлагдмал эрх, өмчлөх эрхийг хамгаалах аргуудын талаар мэдлэг олж авсны дүнд иргэний хууль болон холбогдох бусад хуулиуд дахь өмчийн эрхийг зохицуулах хэм хэмжээг зөв хэрэглэх чадвартай болгоход чиглүүлнэ.

Хичээлийн агуулга:

- Иргэний эрх зүйн системд эд юмсын эрх зүйн гүйцэтгэх үүргийг тодорхойлох
- Эд юмсын эрх зүйн түүхэн хөгжил, түүний үе шат, онцлогийг судлах, өмнөх системийн өмчийн эрх зүйн шинэчлэгдсэн байдлын товчоон

-
- Эд юмсын эрх зүй, үүргийн эрх зүйн ялгаатай тал болон хоорондын уялдаа холбоог тодорхойлох
 - Эд юмсын эрх зүйн онолын суурь мэдлэг эзэмших
 - Эд юмсын эрх зүйн зохицуулалтын хоорондын уялдаа холбоо, логикийн талаар онолын суурь мэдлэгтэй болох
 - Эд юмсын эрх зүйн ойлголт, категоруудыг тайлбарлах
 - Эд юмс болон өмчийн эрх зүйн салбарт гарсан маргааныг онолын үүднээс зөв үнэлэлт дүгнэлт өгч зүйлчлэх чадвар эзэмших

4. КОМПАНИЙН ЭРХ ЗҮЙ

Хичээлийн зорилго:

Энэ хичээлээр иргэний эрх зүйн харилцаанд оролцогч, ашгийн төлөө хуулийн этгээд болох компанийг үүсгэн байгуулах, бүртгүүлэх, өөрчлөн байгуулах, компанийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг тогтоох, компани татан буулгахтай холбогдсон харилцааг судлах зорилготой. Энэхүү хичээлийн хүрээнд компанийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг тусгайлан нарийвчлан судалдгаараа ач холбогдолтой юм.

Хичээлийн агуулга:

Хичээлийн гол агуулга нь компани, түүний эрх зүйн байдал, компани байгуулах, компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах, компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, компанийн хувьцаа, бусад үнэт цаас болон ногдол ашиг, компанийн өмчийг шилжүүлэх, компани өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн

худалдаж авах, хувьцааны хяналтын багцыг худалдан авах, компанийн удирдлага, албан тушаалтны хүлээх хариуцлага, их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтөй хэлцэл, компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт тавих асуудлыг онол-практиктийг түвшинд судална.

5. ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХ ЗҮЙ

Хичээлийн зорилго:

- Оюуны өмчийн эрх зүй хичээлийн зорилго нь оюутанд иргэний эрх зүйн харилцааны хоёр дахь гол объект эдийн бус баялгийн нэг төрөл болох оюуны үнэт зүйлс тэдгээрийн эрх зүйн зохицуулалтын онцлогийг танин мэдүүлэхэд оршино.
- Оюутан энэхүү хичээлийг тусад нь судалсанаар уг салбар эрх зүйн талаар цогц мэдлэг, чадвар хандлагатай болж улмаар суралцагч, цаашдаа эдийн засгийн эрхзүйн салбарт мэргэшин ажиллахад нь чухал ач холбогдолтой.

Хичээлийн агуулга:

- Оюуны өмчийн тухай үзэл баримтлал, оюуны өмчийн эрх зүйн суурь асуудалууд, оюуны өмчийн үндсэн салбар болох Зохиогчийн эрх болон Аж үйлдвэрийн өмчийн эрхийн салбарын тухай ойлголт, зохиогчийн эрхийн объект субъект, шинжлэх ухаан утга зохиол, урлагын бүтээл зохиогчийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, зохиогчийн гэрээний эрх зүйн зохицуулалт, зохиогчийн эрхэд хамаарах эрх, аж үйлдвэрийн өмчийн эрхийн объект, субъект, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар,

барааны тэмдэг, газарзүйн заалтын эрх зүйн зохицуулалт, оюуны өмчийн эрх зүйн бусад асуудал, оюуны бүтээлийн эрхийн хамгаалалт болон оюуны өмчийг бүртгэх, хамгаалах процесс ажлллигааны онцлогийг судална.

6. ГЭМ ХОРЫН ЭРХ ЗҮЙ

Хичээлийн зорилго:

Гэм хор учруулагч, гэм хор учруулсан хэрэгсэл, хариуцлага хүлээх үүрэг бүхий субъект, бусдын амь нас, эрүүл мэнд, эрх, нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд гэм хор учирсан байх, гэм хор учруулагчийн гэм буруутай үйлдэл, эс үйлдэл учирсан гэм хор хоёрын хооронд шалтгаант холбоо байх, уг шалтгаант холбоо нь шууд байх, дээрх ойлголт тус бүрийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэснээр гэрээний бус үүргийн харилцааг зөв зүйлчилж сурах, энэ төрлийн хэрэг маргаанд үндэслэл бүхий хууль зүйн үнэлэлт дүгнэлт өгөх чадварыг оюутанд эзэмшүүлэх зорилготой.

Хичээлийн агуулга:

Гэм хор учруулсанаас үүрэг үүсэх үндэслэлийг нарийвчлан авч үзсэнээр эрх зүйн харилцааны объект, субъект, гэм хор учруулагч болон хохирогчийн гэм буруу ба хариуцага, гэм буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагын хэмжээ, гэм хор учруулагчийн зан үйлийн байдал, эрх зүйн чадамж, эрх зүйн эсрэг зан үйл ба гэм хор хоёрын хоорондох шалтгаант холбоо, гэм буруугүй тохиолдолд хариуцлага хүлээх боломжтой эсэх, гэм хор учруулагч, гэм хорыг хариуцагч нь хоёр өөр этгээд байх зэрэг судалбал зохих асуудал нэг бүрийг нарийвчлан авч үзнэ.

7. ИРГЭНИЙ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ ДЭХ НОТОЛГООНЫ ОНОЛ, АРГА ЗҮЙ

Хичээлийн зорилго:

Шүүхийн нотолгооны ойлголт, онцлог шинж, нотолгооны зүйл, элемент, нотлох баримт, нотолгооны хэрэгслийн талаар цэгцтэй мэдлэг эзэмшиж нотолгооны процесст шүүх болон хэргийн оролцогчдын эрх, эрх үүргийг харьцуулан судласнаар нотлох баримт гаргах, цуглуулах, бүрдүүлэх, хамгаалах, шинжлэн судлах, үнэлэх ажиллагааны онцлогийг танин мэдэж, тодорхой төрлийн хэрэг бүрт нотолгооны зүйлийг зөв тогтоох чадвартай болж цаашид хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх бэлтгэлтэй болоход оршино.

Хичээлийн агуулга:

Шүүхийн нотолгооны тухай ойлголт, онцлог шинж, танин мэдэхүйн онол ба шүүхийн нотолгоо, шүүхийн нотолгооны талаархи үзэл баримтлал, нотолгооны зүйл, түүнийг тодорхой маргаан бүрт тодорхойлох, шүүхийн нотолгооны элемент ба үе шат, мэтгэлзэх зарчим ба шүүхийн нотолгоонд хэргийн оролцогчид идэвхитэй байх тухай, шүүхийн нотолгоонд шүүхийн эрх мэдэл (эрх, үүрэг) нотлох баримт гаргах, цуглуулах, бүрдүүлэх журам, ач холбогдол, нотлох баримтыг шинжлэн судлах, түүний дараалал, нотлох баримтыг үнэлэх түүнд тавигдах шаардлагыг судлана.

8. АРИЛЖААНЫ ХЭЛЦЛИЙН ЭРХ ЗҮЙ

Хичээлийн зорилго:

Арилжааны (Худалдаа) эрх зүйн ойлголт, арилжааны эрх зүйд хамаарах хууль тогтоомжийн онцлогийг судалж, иргэн болон арилжааны эрх зүйн ялгаа

заагийг ойлгох, худалдаачин буюу аж ахуй эрхлэгчийн хийх арилжааны хэлцлийн онцлог, тэдгээрийг хэрэглэхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх арга замыг сурахад оршино.

Түүнчлэн аж ахуй, худалдаа эрхлэгчид хамаарах тусгай хуулийн хэм хэмжээг судлах, хэрэглэгчийн гэрээ ба Арилжааны (Худалдаа) хэлцлийн ялгаа, тодорхой төрлийн гэрээ, тэдгээрийг хэрхэн тайлбарлан хэрэглэх онол арга зүйд суралцана.

Хичээлийн агуулга:

Энэхүү хичээлээр Арилжааны (Худалдаа) хэлцлийн төрөл болох худалдах худалдан авах гэрээ, тээвэрлэлтийн гэрээ, хадгалалтын гэрээ, франчайз, Арилжааны (Худалдаа) зуучлал зэрэг тусгай төрлийн гэрээг судалж, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийнэ.

9. ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙ

Хичээлийн зорилго:

Энэхүү хичээлээр дэлхийн бусад орны эрх зүйн тогтолцоо, өөрөөр хэлбэл жишгийн эрх зүйн бүл, эх газрын эрх зүйн бүл, холимог эрх зүйн бүлд хамаарах улсуудын эрх зүйн тогтолцоо, тухайлсан нэг эрх зүйн салбар хоорондын харьцуулалтыг хийх онолын суурь мэдлэгийг олгохыг зорих бөгөөд үүний үр дүнд оюутнууд өөрийн орны эрх зүйн тухайлсан нэг асуудлыг харьцуулсан эрх зүйн тусламжтайгаар шийдвэрлэх, гарц, шийдлийг хайх аргад суралцана.

Хичээлийн агуулга:

Энэхүү хичээлээр харьцуулсан эрх зүйн ерөхийн ангийн судлагдахуун болох арга зүй, түүх, эрх зүйн уламжлал, бүл, зарчмын талаар, тусгай ангийн

судлагдахуун болох жишгийн эрх зүйн бүл болон эх газрын эрх зүйн бүл, тэдгээрт хамаарах тодорхой улс орны эрх зүйн тогтолцооны талаар судлах болно.

10. ҮНЭТ ЦААСНЫ ЭРХ ЗҮЙ

Хичээлийн зорилго:

Үнэт цаасны зах зээлийн эрх зүй хичээлийн зорилго нь оюутанд үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээл дэх эрх зүйн харилцаа, түүний мөн чанар, онцлогийг танин мэдэж, уг асуудлаар хууль зүйн дүгнэлт өгөхөд шаардлагатай онолын болон практик мэдлэг олгож, эрх зүйн эх сурвалжийг сонгож хэрэглэх чадвар эзэмшүүлэхэд чиглэнэ.

Хичээлийн агуулга:

Даяарчлагдаж буй орчин үеийн эдийн засагт санхүүгийн зах зээл, түүний дотор хөрөнгийн зах зээлийн гүйцэтгэх үүрэг, байр суурь, эдийн засагт үзүүлэх нөлөө нэмэгдсээр байна. Бизнесийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалтын хямд, урт хугацаат эхүүсвэрийг бий болгох боломжийг олгодог энэхүү зах зээлийн зарчим, дэг журмыг эрх зүйн зохицуулалтын хүрээнд тогтоох зайлшгүй шаардлагатай тул хувийн эрх зүйн чиглэлээр ажиллах мэргэжилтний хувьд хөрөнгийн зах зээлд үйлчлэх дүрэм журам, эрх зүйн зохицуулалтын талаар үндсэн мэдлэгтэй байх шаардалагатай. Үнэт цаасны зах зээлийн эрх зүй хичээлийг судалснаар оюутан үнэт цаасны зах зээлийн талаар онол, практикийн суурь мэдлэгтэй болж, тэдгээрийн эдийн засгийн ач холбогдлыг ойлгож, уг заал дэх хууль зүйн фактын талаар үндэслэл бүхий дүгнэлт хийх чадварыг эзэмших юм.

11. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН ЭРХ ЗҮЙ

Хичээлийн зорилго:

Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн тухай ойлголт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохицуулахад төрийн оролцох оролцоо, чиг үүрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйгээр зохицуулагдах харилцаа, түүний эрх зүйн зохицуулалт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн бусад салбар эрх зүйтэй холбоотой болон бусад салбар эрх зүйгээс ялгагдах онцлогийн тухай онол, практикийн мэдлэгийг эзэмшүүлэх, төрөөс шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар явуулж байгаа бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор хууль тогтоох байгуулгаас батлан гаргасан хууль тогтоомжийг онол практикийн үүднээс танин мэдэх, энэ асуудлыг эрхэлсэн байгууллагын үйл ажиллагаатай танилцах, нийгмийн амьдралд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бодитойгоор хэрэгжүүлэхэд оролцох чадвар эзэмшүүлэхийн зэрэгцээ аливаа шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд хуулиар зөвшөөрөгдсөн үзэл баримтлал, зарчмын үүднээс хандах дадлыг оюутанд төлөвшүүлэхэд оршино.

Хичээлийн агуулга:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндсэн асуудал, зарчим, шийдвэр гүйцэтгэх үндэслэл, шийдвэр гүйцэтгэх байгууллага, түүний тогтолцоо, шийдвэр гүйцэтгэх баримт бичиг, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх, түдгэлзүүлэх, дуусгавар болгох, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогчид тэдний эрх, үүрэг, төлбөр төлөгчийн эд хөрөнгөнөөс төлбөр гаргуулах ажиллагаа, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал, шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд гомдол гаргах зэрэг асуудлыг судална

12.ШҮҮХИЙН БУС АРГААР МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙ

Хичээлийн зорилго:

Иргэний маргааныг арбитр болон эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтын талаар онолын мэдлэг олж, улмаар онолын мэдлэгтээ тулгуурлан шүүхийн бус аргаар маргаан хянан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг практикт хэрэгжүүлэх ур чадварыг эзэмшүүлнэ. Ингэснээр иргэний хэрэг, маргааныг үндэслэлтэйгээр шүүхийн бус аргаар шийдэхэд хуульчийн сэтгэхгүйг онол-практикийн төвшинд хослуулан хөгжүүлэх ач холбогдолтой.

Хичээлийн агуулга:

Монголоор: Хичээлийн гол агуулга нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зорилго, үндсэн зарчим, эвлэрүүлэн зуучлах журмаар маргаан шийдвэрлэх харьяалал, эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогчид тэдгээрийн эрх үүрэг, эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүй, эвлэрлийн гэрээ, эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангах, иргэний хэрэгт эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх, хөдөлмөрийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа, гэр бүлийн холбогдолтой маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа, арбитрын ажиллагаа үүсэх, арбитрын бүрэлдэхүүн, арбитрын бүрэлдэхүүний эрх хэмжээ, арбитрын процессын онцлог, арбитрын хэлэлцээр, арбитрын хэлэлцээр хүчин төгөлдөр болох нөхцөл, компетенц зарчим, арбитрын ажиллагаанд шүүх оролцох нөхцөл, журам, арбитрын шийдвэр хүчин төгөлдөр бус болох ойлголтын талаар судална.

13. ОЛОН УЛСЫН ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХ ЗҮЙ

Хичээлийн зорилго:

Энэхүү хичээлийн зорилго нь олон улсын хэмжээнд оюуны өмчийг хамгаалах, худалдахтай холбоотой харилцааг зохицуулж буй олон улсын гэрээ хэлэлцээртэй танилцах, тэдгээрийг тайлбарлах, хэрэглэж сурахад оршино.

Хичээлийн агуулга:

- Олон улсын оюуны өмчийн эрх зүйн түүхэн хөгжил, ойлголт
- Оюуны өмчийн олон улсын байгууллагууд
- Зохиогчийн болон холбогдох эрхийг хамгаалах
- Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах
- Шударга өрсөлдөөний талаар үндэсний хэм хэмжээ ба олон улсын гэрээ
- Бусад олон улсын гэрээ
- Дэлхийн худалдааны байгууллагын оюуны өмчийн худалдаатай холбоотой ТРИПС-ын хэлэлцээр
- Франчайзингийн гэрээ болон бусад эрх олгох гэрээ
- Оюуны өмчийн талаар Монгол улсын эрх зүй

14. ОЛОН УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙ

Хичээлийн зорилго:

Олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүй нь сүүлийн жилүүдэд хуульч, судлаачдын дунд ихээхэн сонирхолтой сэдэв болоод байгаа билээ. Очир нь өөр өөр эрх зүйн тогтолцооны огтлолцол дээр оршдог бөгөөд арилжааны болон хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх арбитрын

процесстой нягт холбогдож, олон улсын эдийн засгийн эрх зүй болон олон улсын эдийн засгийн нийтийн эрх зүй судлаачдад хамаардаг.

Тийм ч учраас дан ганц нэг сэдэв бус, харин олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүй хэмээх бүтэц, үндсэн асуудлыг бүхэлд нь судалж толилуулах нь ихээхэн ач холбогдолтой юм.

Хичээлийн агуулга:

Энэхүү хичээлийн хөтөлбөрийн дагуу олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн тухай ойлголт, эх сурвалжаас гадна хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах үндсэн зарчим, зохицуулалт, олон улсын хөрөнгө оруулалтын гэрээний төрөл, ангилал, онцлог, тэдгээрийн гол нөхцөл, хөрөнгө оруулалтын гэрээний маргаан шийдвэрлэх үндсэн асуудал, хөрөнгө оруулалтын гэрээний арбитрын шийдвэрийг биелүүлэх асуудлыг судлах бөгөөд дан ганц онолын бус, сэдэв тус бүрт холбогдох арбитрын шийдвэрийг судалж практикийн мэдлэгийг ч олж авах юм. Семинарын хичээлийн хувьд олон улсын болон үндэсний эрх зүйн хэм хэмжээг хэрэглэж олон улсын хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх асуудлын үндсийг судлах ба дадлагажих шүүх хуралдаан буюу Moot Court хэлбэрээр гол төлөв явагдана.

Хичээлээр дээр дурьдсан мэдлэг чадварыг оюутан олж авах бөгөөд олон улсын эдийн засаг, хөрөнгө оруулалтын эрх зүйн харилцаа улам бүр өргөжиж байгаа өнөө үед хөрвөх чадвартай, нэн ялангуяа эдийн засгийн тэргүүлэх чиглэлд хуульчаар ажиллахад дөхөм болох юм.

15. ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ

Хичээлийн зорилго:

Орчин үеийн ИПЭЗ-ын нэгэн онцлог бол иргэний

эрх зүйн эрх, эрх чөлөөг зөвхөн үндэсний түвшинд төдийгүй олон улсын түвшинд ч мөн хамгаалах боломж бий болсон явдал юм. Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай 1950 оны Европын конвенц болон 1966 оны иргэний ба улс төрийн эрхийн тухай Пактад зааснаар хувийн өргөдөл нэхэмжлэлийг олон улсын байгууллага, шүүхэд хянан шийдвэрлэх боломжийг олгосон. Тиймээс энэхүү хичээлийг судлахад ач холбогдолтой юм. Түүнчлэн аливаа хэргийн харъяаллын асуудлыг олон улсын өнцгөөс харах хандлага төлөвшүүлнэ.

Хичээлийн агуулга:

- Олон улсын иргэний процессийн ойлголт, эх сурвалж
- Иргэний болон худалдааны хэргийн олон улсын харьяалал
- Олон улсын хамтын ажиллагаа ба эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх
- Гадаад улсын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх
- Монгол Улсын шүүхийн хэрэг харьяалах бүрэн эрх
- Шүүхийн даалгавар
- Нотариатын үйлдэл
- Олон улсын худалдааны арбитрын хэргийн харьяалал, арбитрын хэлэлцээр
- Арбитрын бүрэлдэхүүн, арбитрчийг томилох, татгалзан гаргах, арбитрын ажиллагаа
- Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, гүйцэтгэх
- Арбитрын үйл ажиллагаан дахь шүүхийн оролцоо
- Хөрөнгө оруулалтын маргааныг хянан шийдвэрлэх

16. ОЛОН УЛСЫН ГЭР БҮЛ, ӨВ ЗАЛГАМЖЛАЛЫН ЭРХ ЗҮЙ

Хичээлийн зорилго:

Энэ хичээлийн гол зорилго нь оюутан гэр бүл өв залгамжлалын олон улсын эрх зүйн зохицуулалт, энэ талаар гарч буй хэрэг маргааныг шийдвэрлэх практикийг нарийвчлан судална.

Хичээлийн агуулга:

Хичээлээр дараах сэдвийг судална. Үүнд: Гэр бүл болоход тавигдах шаардлага, гэрлэх хэлбэрийн талаар үндэсний ба олон улсын эрх зүйн зохицуулалт, гадаад улсад бүртгүүлсэн гэрлэлтийг хүлээн зөвшөөрөх, гэрлэгсдийн эд хөрөнгийн болон тэжээн тэтгэх харилцаа, эцэг эх болон хүүхдийн харилцаа, гэрлэлт цуцлахад хэрэглэх эрх зүйг тодорхойлох, гадаадад гэр бүл цуцлуулсан шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, олон улсын шинжтэй үрчлэлтэд хэрэглэх эрх зүй, олон улсын өв залгамжлалын эрх зүй, хууль ёсоор өвлөх, гэрээслэл үйлдэх өөрчлөхөд хэрэглэх эрх зүйг тодорхойлох зэрэг болно.

17. ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ

Хичээлийн зорилго:

Хичээлийн зорилго нь олон улсын хэмжээнд бараа худалдах, тээвэрлэх зэрэг олон улсын худалдаа (арилжаа)-ны гэрээтэй холбоотой олон улсын гэрээ хэлэлцээрийн талаар мэдлэг олж авах, тэдгээрийг зөв тайлбарлаж, ойлгох, практикт хэрэглэж сурахад оршино.

Хичээлийн агуулга:

Олон улсын хэмжээнд бараа худалдах, худалдан авах тухай НҮБ-ын Конвенц, Олон улсын арилжааны гэрээний тухай УНИДРУА-ийн зарчим, Инкотермсийн нөхцөл, олон улсын хэмжээнд авто замаар, төмөр замаар, агаараар, усан замаар ачаа тээвэрлэх эрх зүйн журам, олон улсын худалдаа (арилжаа)-ны гэрээнээс үүдэлтэй маргааныг шийдвэрлэх олон улсын механизм, түүнд баримтлах журам, шүүх, арбитрийн практик, олон улсын худалдаа (арилжаа)-ны гэрээний төсөл боловсруулахад анхаарах асуудлыг судлана.

Тэмдэглэл

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Тэмдэглэл

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Тэмдэглэл

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Тэмдэглэл

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....